



ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ХЯНАЛТ,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 06 сарын 16 өдөр

Дугаар А/132

Улаанбаатар хот

“Фармакопей боловсруулах, батлах болон
фармакопейн хорооны ажиллах журмыг шинэчлэн
боловсруулах ажлын хэсэг байгуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3, 23.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Фармакопей боловсруулах, батлах болон фармакопейн хорооны ажиллах журам”-ыг шинэчлэн боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. Ажлын хэсгийн үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангаж, удирдамжийн дагуу ажиллахыг ажлын хэсгийн дарга (Д.Уранзаяа)-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын газар (Б.Батбаяр)-т даалгасугай.

ДАРГА



Д.НАРАНТУЯА

1422 0-0131